



ХОТ БАЙГУУЛАЛТ,
БАРИЛГА, ОРОН
СУУЦЖУУЛАЛТЫН ЯАМ

ХОТ БАЙГУУЛАЛТ, ОРОН СУУЦЖУУЛАЛТЫН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ОРОН СУУЦНЫ САНХҮҮЖИЛТ, ЗЭЭЛИЙН СУДАЛГАА, ТӨЛӨВЛӨЛТ ХАРИУЦСАН АХЛАХ
МЭРГЭЖИЛТЭН СОДНОМДАРЖАА ОВОГТОЙ БҮЖМААГИЙН
2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Хянасан:

ХОТ БАЙГУУЛАЛТ, ОРОН СУУЦЖУУЛАЛТЫН
БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГА
(албан тушаал)

Тэмдэг

Тайлан гаргасан:

ХОТ БАЙГУУЛАЛТ, ОРОН СУУЦЖУУЛАЛТЫН
БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ОРОН
СУУЦНЫ САНХҮҮЖИЛТ, ЗЭЭЛИЙН СУДАЛГАА,
ТӨЛӨВЛӨЛТ ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН
(албан тушаал)

Нэгжийн дарга

/О.ОДБАЯР/
(гарын үсэг)

20.25.12.18

Албан хаагч

/С.БҮЖМАА/
(гарын үсэг)

20... ..

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2023 оны 98 дугаар тушаалын 6 дугаар хавсралт

ХОТ БАЙГУУЛАЛТ, ОРОН СУУЦЖУУЛАЛТЫН БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
 ОРОН СУУЦНЫ САНХҮҮЖИЛТ, ЗЭЭЛИЙН СУДАЛГАА, ТӨЛӨВЛӨЛТ ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН
 СОДНОМДАРЖАА ОВОГТОЙ БҮЖМААГИЙН 2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТАЙЛАН

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээ

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
Зорилт 1.2.2 “ӨРХИЙН ТӨЛБӨРИЙН ЧАДВАРТ НИЙЦҮҮЛЭН ИПОТЕКИЙН ХӨНГӨЛӨЛТТЭЙ ЗЭЭЛИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙГ ТӨРӨЛЖҮҮЛЖ, ХҮРТЭЭМЖИЙГ НЭМЭГДҮҮЛНЭ” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД: ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ. ЗГҮАХ. 2.4.1.2, 2.4.1.3, 2.4.1.8, ЗГҮАХХАХТ: 2.4.1.2							
1.2.2.1	Арга хэмжээ: “Миний анхны байр” хөтөлбөрийг хэрэгжүүлж, залуу гэр бүл анх удаа байр худалдан авахад нь дэмжлэг үзүүлэх ЗГҮАХХҮТ 1.4.1.5, N466	Хамрагдах өрхийн тоо өссөн дүнгээр	8,889	17,889	Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн 10.1.2.-д “Хуримтлалын сан нь газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг одоо үеийн Монгол Улсын иргэн бүрд тэгш, шударга хүртээх зорилгоор иргэний эрүүл мэнд, боловсрол, орон сууцны зориулалтаар дэмжлэг үзүүлэх” гэж заасны дагуу Уул уурхайн олборлолт, ашигт малтмал боловсруулах салбарын төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн цэвэр ашгаас 2024 онд 495.65 тэрбум, 2025 онд 480.2 тэрбум төгрөгийг хуримтлалын сангаар дамжуулан орон сууцны хөнгөлөлттэй зээлийн хөтөлбөрийн санхүүжилтийг нэмэгдүүлсэн. Ипотекийн орон сууцны хөнгөлөлттэй зээлийн хөтөлбөрийн хүрээнд 2025 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн байдлаар нийт 1,122.93 тэрбум төгрөгийн ипотекийн зээлийг 8,841 зээлдэгчид олгож, нийт 17,730 зээлдэгчид олгожээ. Цаашид Орон сууцны санхүүжилтийн банкны тухай хууль батлагдснаар иргэдийн орон сууцжуулах урт хугацааны, тогтвортой санхүүжилтийн тогтвортой эх үүсвэрийг бүрдүүлэн, арилжааны банкуудад	01-12	100%

0	1	2	3	4	5	6	7
					хуваарилж, ипотекийн хөтөлбөрийг сайжруулан иргэдийн орлогын түвшин бүрд тохирсон хөтөлбөрүүдийг санал болгох, хамрагдах шаардлагагүй хүмүүсийг хамруулахгүй хязгаар тавих замаар зээлийн бүтээгдүүнийг санал болгон иргэдийг орон сууцжуулах эрх зүйн орчин тодорхой болно.		
1.2.2.2	<p>Арга хэмжээ: Ипотекийн хөнгөлөлттэй зээлийн бүтээгдэхүүнийг төрөлжүүлж, хүүг ялгаатай тогтоох замаар зах зээлийн зарчимд нийцүүлэх ЗГҮАХХҮТ 2.4.1.2, N467</p>	Журмын өөрчлөлт	-	Журамд өөрчлөлт оруулах саналыг холбогдох байгууллагад хүргүүлсэн байна.	<p>"Ипотекийн хөнгөлөлттэй зээлийн бүтээгдэхүүнийг төрөлжүүлж, хүүг ялгаатай тогтоох замаар зах зээлийн зарчимд нийцүүлэх нь" сэдэвт уулзалтыг 2025 оны 01 дүгээр сарын 20-ны өдөр холбогдох байгууллагуудын албан хаагчдыг оролцуулан зохион байгуулж, Монголбанкны Ерөнхийлөгчийн 2016 оны А-295 дугаар тушаалаар батлагдсан "Орон сууцны ипотекийн санхүүжилтийн журам"-ын холбогдох заалтуудад өөрчлөлт оруулахаар тохирсон. Тус журмын холбогдох заалтад өөрчлөлт оруулах саналын төслийг боловсруулан холбогдох байгууллагуудад танилцуулан Үндэсний баялгийн сан, орон сууцжуулалтын үндэсний хорооны ээлжит хуралдаанаар хэлэлцүүлэхээр хүлээгдэж байна. Олон улсад амжилттай хэрэгжүүлсэн орнуудын сайн туршлага болон Үндэсний хороо, Дэлхийн банкнаас хийгдсэн судалгаанд үндэслэн банкны үйл ажиллагааны бүтэц, санхүүжилтийн схем, засаглалын шийдлийн талаарх саналыг боловсруулж, Засгийн газрын хуралдаанд танилцуулан ажиллаж байгаа бөгөөд эхний байдлаар 2025 оны намрын чуулганаар "Орон сууцны санхүүжилтийн банкны тухай" хуулийн төслийг хэлэлцүүлж, 2026 оны эхний улиралд багтаан "Орон сууцны санхүүжилтийн банк"-ийг байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.</p>	01-12	100%

0	1	2	3	4	5	6	7
1.2.2.3	<p>Арга хэмжээ: “Миний сонголт орон нутаг” хөтөлбөрийн хүрээнд Улаанбаатар хотоос орон нутагт шилжин суурьшсан болон аймаг, сум, Улаанбаатар хотын алслагдсан дүүрэгт анх удаа орон сууц худалдан авах иргэдэд арилжааны банкнаас олгох ипотекийн зээлийг 3%-ийн хүүтэй хөнгөлөлттэй нөхцлөөр олгох бодлогыг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ. ЗГҮАХХҮТ 2.4.1.8 №467 ЗГҮАХХҮТ: 1.2.2.2, 1.4.1.2, 2.4.1.2 №468, 2.4.1.8 №476</p>	Ипотекийн зээлийн татаасанд хамрагдах өрх тоогоор	993	4,762	<p>“Хот, хөдөөгийн сэргэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2023 оны 68 дугаар тогтоолын 1 дэх заалтыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын төвлөрлийг бууруулж, орон нутагт шилжин суурьшиж байгаа болон 21 аймаг, нийслэлийн алслагдсан Багахангай, Багануур, Налайх дүүрэгт оршин сууж байгаа төрөөс хэрэгжүүлж буй орон сууцны ипотекийн зээлд анх удаа хамрагдаж байгаа иргэдийг дэмжиж, Улаанбаатар хотоос орон нутагт шилжин суурьшиж буй болон орон нутгийн байнгын оршин суугч иргэний тухайн орон нутгаас анх удаа, шинээр худалдан авч буй орон сууцны ипотекийн хөнгөлөлттэй зээлийн хүү жилийн 6 хувь бөгөөд эхний 3 жилийн хүүгийн 50 хувь буюу 3 нэгж хувийг Засгийн газраас татаас хэлбэрээр дэмжлэг үзүүлж, хүүгийн зөрүү мөнгөн хөрөнгийг Засгийн газраас хариуцан төлж байна.</p> <p>Энэ хүрээнд “Ипотекийн зээлийн орон нутгийн орон сууцны санхүүжилтийн ерөнхий гэрээ”-г ХББОС-ын сайд, Сангийн сайд, Монголбанкны ерөнхийлөгч, арилжааны банкууд, Зээлийн батлан даалтын сантай байгуулан 2025 оны 03 дугаар сарын 20-ны өдөр эцэслэн баталсан.</p> <p>2025 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн байдлаар орон нутагт 3,217 зээлдэгчид нийт 375.01 тэрбум төгрөгийн ипотекийн зээл авснаас 843 зээлдэгчид нийт 98.3 тэрбум төгрөгийн 3 хувийн ипотекийн зээл олгосон байна. 3 хувийн ипотекийн зээл олгож эхэлсэн 2023 оноос хойш нийт 4,810 зээлдэгч тус хөтөлбөрт хамрагджээ.</p> <p>Зээлийн батлан даалтын сангаас урьдчилгаа ипотекийн төлбөрийн батлан даалтад 2025 онд 281 зээлдэгч 6.02 тэрбум төгрөгийн батлан даалт гаргуулсан байна. Ипотекийн төлбөрийн батлан даалт гаргаж эхэлсэн 2023 оноос нийт 1,557 зээлдэгчид батлан даалт гаргасан байна.</p>	01-12	100%
		Хөдөө орон нутагт олгох ипотекийн зээлийн урьдчилгаа төлбөрт батлан даалтад хамрагдсан өрх өссөн тоогоор	219	1,200			

0	1	2	3	4	5	6	7
1.2.2.4	Арга хэмжээ: Залуу гэр бүл орон сууц худалдан авахад зориулж урьдчилгаа төлбөрт нь батлан даалт гаргадаг тогтолцоог бий болгох ЗГҮАХХҮТ: 2.1.1.35	Холбогдох дүрэм журмын шинэчлэлтийн тоогоор	-	1	“Орон сууцжуулалтийн тухай” хуулийн дагалдах хуулийн төсөлд Зээлийн батлан даалтын сангийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.1 дэх хэсэгт нэмэлт өөрчлөлт оруулахаар дагалдах хуулийн төсөлд тусган батлуулахаар ажиллаж байна.	07-12	100%
1.2.2.5	Арга хэмжээ: Ипотекийн зээлийн санхүүжилтийн эх үүсвэрийг нийслэлийн гэр хорооллын дахин төлөвлөлтийн байршлуудад тэргүүн ээлжинд олгуулах арга хэмжээг зохион байгуулна. ЗГҮАХ: 1.1.3.3 ЗГҮАХХҮТ: 39	Зээлд хамрагдсан иргэдийн тоо	6,378	8,178	Үндэсний баялгийн сан, орон сууцжуулалтын үндэсний хороо, Монголбанк, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Хот төлөвлөлт хотын стандартын газар, Нийслэлийн Орон сууцны бодлогын газар, "Шинэ Сэргэлтийн Бодлогын Хурдасгуур Төв" УТҮГ-ын холбогдох албан тушаалтнуудыг хамруулсан "Ипотекийн хөнгөлөлттэй зээлийн бүтээгдэхүүнийг төрөлжүүлж, хүүг ялгаатай тогтоох замаар зах зээлийн зарчимд нийцүүлэх нь" сэдэвт уулзалтыг 2025 оны 01 дүгээр сарын 20-ны өдөр зохион байгуулж, Монгол банкны Ерөнхийлөгчийн 2016 оны А-295 дугаар тушаалаар батлагдсан “Орон сууцны ипотекийн санхүүжилтийн журам”-ын холбогдох заалтуудад өөрчлөлт оруулахаар тохирсон. Журамд өөрчлөлт оруулах саналын төслийг боловсруулан холбогдох байгууллагуудад танилцуулсан. Үндэсний баялгийн сан, орон сууцжуулалтын үндэсний хорооны ээлжит хуралдаанаар хэлэлцүүлэхээр хүлээгдэж байсан боловч Ерөнхий сайдын 45 дугаар захирамж, Засийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 112-р тушаалаар ажлын хэсгүүдийн хүрээнд боловсруулж буй “Орон сууцны санхүүжилтын тухай” хуулийн төсөлтэй холбогдуулан хүлээгдэж байна. Мөн “Төрөөс мөнгөний бодлогын талаар 2026 онд баримтлах үндсэн чиглэл”-ийн төсөлд ипотекийн зээлийн санхүүжилтийн эх үүсвэрийг нийслэлийн гэр хорооллын дахин төлөвлөлтийн байршлуудад тэргүүн ээлжинд олгуулах арга хэмжээг Амины орон сууцанд ипотекийн зээл олгох замаар хэрэгжүүлэхээр	01-12	100%

0	1	2	3	4	5	6	7
					<p>тусгуулаад байна. Ипотекийн орон сууцны хөнгөлөлттэй зээлийн хөтөлбөрийн хүрээнд нийслэлийн хэмжээнд 2025 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн байдлаар 747.9 тэрбум төгрөгийн ипотекийн зээлийг 5,624 зээлдэгчид олгож, нийт 12,002 зээлдэгчид олгожээ.</p>		
<p>1.2.2.6</p>	<p>Арга хэмжээ: “Хашаандаа сайхан амьдаръя” хөтөлбөрийг хэрэгжүүлж, эрчим хүчний хэмнэлттэй, байгаль орчинд ээлтэй, амины орон сууц шинээр барих, засварлахад хөнгөлөлттэй зээл болон бусад дэмжлэг үзүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлнэ. ЗГҮАХХҮТ: 1.1.3.7, 2.4.1.5, 2.4.2.2, 3.4.2.9,</p>	<p>Холбогдох эрх зүйн баримт бичиг оруулсан өөрчлөлтийн тоогоор</p>	<p>-</p>	<p>Ипотекийн зээлийн журамд Шинээр амины орон сууц барих, худалдан авахад болон гамшигт тэсвэртэй, барилгын норм ба дүрмийг хангаж өөрийн орон сууцны нөхцөлийг сайжруулан засварласан өрхөд ипотекийн зээл олгодог өөрчлөлт оруулсан байна.</p>	<p>Ипотекийн зээлийн санхүүжилтэд Амины орон сууцыг хамруулах үйл ажиллагааг тодорхой болгох зорилгоор Монголбанкт хамтран ажиллаж, Монголбанкны ерөнхийлөгчийн 2016 оны А/295 дугаар тушаалаар баталсан “Орон сууцны ипотекийн санхүүжилтийн журам”-ын 1.2.13 дахь заалтад 2024.10.09-ний өдөр өөрчлөлт оруулж, “Амины орон сууц” гэх нэр томъёоны ойлголтыг нарийвчлан тодорхойлсон. Амины орон сууцны ипотекийн зээлийн хөтөлбөрт оролцогч арилжааны банкуудад журмын өөрчлөлт, эрчим хүчний хэмнэлттэй амины орон сууцыг үнэлэх үнэлгээний систем (BestGer), тавигдах шаардлагын талаар мэдээлэл, зөвлөгөө өгөх уулзалтыг Монголбанкт хамтран 2024.12.13-ны өдөр зохион байгуулсан. Амины орон сууцны ипотекийн зээлийн санхүүжилтийг ямар аргачлалаар олгох талаар 2025 оны 01 дүгээр сарын 20-ны өдөр “Монголын банкны холбоо” ГҮТББ-ийн Зээлийн эрсдлийн хороогоор хэлэлцүүлж, Нийслэл Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг батлуулах, Ногоон барилгын аудитор бэлтгэсний дараа дахин хэлэлцэхээр тохиролцсон. “Дулаан байшин - Амины орон сууцны нээлттэй өдөрлөг” нь 2025 оны 05 дугаар сарын 04-07-ны өдрүүдэд Нийслэлийн төв талбайд зохион байгуулж, салбарын төрийн бус байгууллага, аж ахуй нэгж байгууллага, олон улсын байгууллагын төлөөлөл, банк санхүүгийн салбарын нийт 91 байгууллагын төлөөлөл оролцож нийт 10,000 орчим, давхардсан</p>	<p>01-12</p>	<p>100%</p>

0	1	2	3	4	5	6	7
					<p>тоогоор 29,562 иргэнд эрчим хүчний хэмнэлттэй, дулаан алдагдалгүй, тэсвэртэй, ногоон амины орон сууц барих, нөхцөл сайжруулах, дулаалах дэвшилтэт технологийн шийдлүүдийг танилцууллаа.</p> <p>“Ногоон барилгын аудитор бэлтгэх сургалт”-ыг 2025 оны 05 дугаар сарын 19-ны өдрөөс эхлэн 05 дугаар сарын 27-ны өдрийн хооронд зохион байгуулсан бөгөөд сургалтанд нийт 54 инженер технологийн ажилтан хамрагдаж 11 нь шалгалтад тэнцэж аудиторын гэрчилгээ авсан.</p> <p>Мөн амины орон сууцанд ипотекийн зээл олгох үйл ажиллагааг эрчимжүүлэх үүдээс 2025.09.25-ны өдөр Монгол банк, Ногоон барилгын хүрээлэнтэй уулзалтаар ипотекийн санхүүжилтийн эх үүсвэрийн тодорхой хувийг ирэх оноос амины орон сууцанд олгохоор хуваарилах, үнэлгээний шалгуур үзүүлэлтийн талаар хэлэлцэж, Монголбанкны ерөнхийлөгчийн 2016 оны А/295 дугаар тушаалаар баталсан “Орон сууцны ипотекийн санхүүжилтийн журам”-д өөрчлөлт оруулахаар тохиролцлоо.</p> <p>Ипотекийн хөтөлбөрийн хүрээнд энэ оны эхний хагаст нийт 1.3 тэрбум төгрөгийн зээлийг амины орон сууц худалдан авч буй зээлдэгчид олгоод байна</p>		
1.2.2.7	<p>Арга хэмжээ: “Миний амины орон сууц” хөтөлбөрийн хүрээнд гэр хорооллын иргэдэд эрчим хүчний хэмнэлттэй амины орон сууц барьсан тохиолдолд 30 сая төгрөгийн санхүүжилтийн дэмжлэг үзүүлнэ.</p> <p>ЗГҮАХ: 2.4.1.7, ЗГҮАХХАХТ: 2.4.1.7 № 475, 3.4.2.9</p>	Журмын төсөл ЗГ-ын тогтоолын төсөл	-	Эрчим хүчний хэмнэлттэй амины орон сууц барьсан тохиолдолд дэмжлэг үзүүлэх журмын төсөл боловсруулсан байна.	<p>Эрчим хүчний хэмнэлттэй хувийн сууцны урьдчилгаа төлбөрийн татаасын санхүүжилтийн журмын зорилго нь хот суурин газрын ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан амины орон сууцны бүсэд эрчим хүчний үр ашигтай хэрэглээг дээшлүүлэх, барилгын салбарт эрчим хүчний хэрэглээг бууруулахад урьдчилгаа төлбөрийн татаас бүхий эрчим хүчний хэмнэлттэй амины орон сууц барих болон сайжруулахад 30 хүртэлх сая төгрөгийн татаас олгох нөхцөл, шаардлагыг тодорхойлох, татаасын санхүүжилтийг олгох, зарцуулах, түүнд хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулах 6 бүлэгтэй “Амины орон сууц шинээр барих болон сайжруулахад төрөөс татаас олгох журам”-ын төслийг боловсруулан ХББОСЯ-ны</p>	01-06	100%

0	1	2	3	4	5	6	7
					<p>цахим хуудаст байршуулан санал авч байна. Одоогийн байдлаар байгууллагын албан хаагчдаас 2 санал ирүүлсэн байна. Нийслэл Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний төсөлд Улаанбаатар хотод 60 гаран мянган өрхийн багтаамжтай сайжруулсан гэр хорооллын бүсийг тогтоосон байгаа бөгөөд Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний төсөл УИХ-аар хэлэлцэгдэх хүлээгдэж байна. Тус яамнаас Орон сууцжуулалтын тухай хуулийн төсөл боловсруулж байгаатай холбогдуулан журмын төсөлд өөрчлөлт орж байгаа тул эдгээр хуулийн төслийг дагалдуулан журмын төслийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанд танилцуулахаар төлөвлөн ажиллаж байна.</p>		

Зорилт 3. Төрийн жинхэнэ албан хаагчийн нийтлэг үүргийг хэрэгжүүлж ажиллах

1.	<p>Арга хэмжээ 3.1: Дээд шатны байгууллага, бусад яамд, холбогдох газруудаас санаачлан боловсруулсан хууль тогтоомж, бодлого, төлөвлөлтийн баримт бичгүүдэд санал өгч, салбар хоорондын зохицуулалтыг хангаж ажиллана.</p>	Төсөлд өгсөн саналын тоо	-	-	<ul style="list-style-type: none"> - ХББОСЯ-ны ТНБД-ын 2024 оны А/52 дугаартай тушаалаар байгуулагдсан “МУ-ын хөгжлийн 2026 оны төлөвлөгөөний төсөл”-д тусгуулах салбарт хэрэгжүүлэх арга хэмжээний саналыг нэгтгэн боловсруулж 2025 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 01/15 тоот албан бичгээр ЭЗХЯ-нд хүргүүлсэн. - Тус яам нь Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам болон өөрчлөгдсөнтэй холбогдуулан хөнгөлөлттэй зээлийн хүүгийн татааст шаардлагатай 63.5 тэрбум төгрөгийг Монгол Улсын 2025 оны төсвийн хуульд манай сайдын багцад тусгагдан баталснаар Засгийн газрын 2025 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн 68 дугаар тогтоолоор “Хот, хөдөөгийн сэргэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2023 оны 2 дугаар сарын 28-ны өдрийн 68 дугаар тогтоолын 1 дүгээр зүйлийн “Монголбанк /Б.Лхагвасүрэн/-д зөвлөж,” гэсний дараа “Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам 	01-12	100%
----	-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------	--------------------------	---	---	--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------	-------	------

0	1	2	3	4	5	6	7
					<p>/Ж.Батсуурь/,” гэж нэмэлт өөрчлөлт оруулах 3Г-ын тогтоолын төсөл бэлтгэж батлуулав.</p> <p>- “Ипотекийн зээлийн орон нутгийн орон сууцны санхүүжилтийн ерөнхий гэрээ”-ний төслийг боловсруулан ХББОС-ын сайд, Сангийн сайд, Монголбанкны ерөнхийлөгч, арилжааны банкууд, Зээлийн батлан даалтын сантай 2025 оны 03 дугаар сарын 20-ны өдөр эцэслэн батлуулав.</p>		
2.	<p>Арга хэмжээ 3.2: Хариуцсан асуудлаар дээд шатны байгууллага, удирдлага, холбогдох байгууллага, иргэдийг бодит мэдээ, мэдээллээр хангаж ажиллана.</p>	<p>Мэдээ, мэдээллээр хангаж ажилласан байдал</p>	-	-	<p>- Улсын Их Хурлын гишүүн Ж.Галбадрахын 2025 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн 11 дугаартай албан бичгээр Боловсролын ерөнхий хуулийн хэрэгжилттэй танилцах, бүх шатны сургуулийн багшийн хомсдолыг бууруулах, үнэлэмжийг дээшлүүлэх болон төрийн өмчийн ерөнхий боловсролын сургуулийн менежментийг сайжруулах асуудлыг судалж, санал, дүгнэлт гаргах ажлын хүрээнд шаардлагатай мэдээллийг гаргаж ирүүлэх хүсэлтийн дагуу холбогдох мэдээллийг гаргаж 2025 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн 01/1178 дугаартай албан бичгээр хүргүүлэв.</p> <p>- Улсын Их Хурлын гишүүн Ж.Алдаржавхлангийн 2025 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн УИХ-03/11309 дугаартай албан бичгээр Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооны 2025 оны 06 дугаар тогтоолоор батлагдсан “Монголбанкнаас хэрэгжүүлж буй орон сууцны ипотекийн зээлийн үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг хянан шалгаж, санал дүгнэлт гаргах” ажлын хүрээнд шаардлагатай мэдээллийг гаргаж ирүүлэх хүсэлтийн дагуу холбогдох мэдээллийг гаргаж 2025 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн 01/3747 дугаартай албан бичгээр хүргүүлэв.</p> <p>- Улсын Их Хурлын гишүүн С.Цэнгүүнийн 2025 оны 03/11897 дугаартай албан бичгээр Гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж буй төсөл хөтөлбөрүүдийн талаарх мэдээллийг гаргаж</p>	01-12	100%

0	1	2	3	4	5	6	7
					<p>ирүүлэх хүсэлтийн дагуу холбогдох мэдээллийг гаргаж 2025 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн 01/4160 дугаартай албан бичгээр хүргүүлэв.</p> <p>- Улсын Их Хурлын гишүүн О.Саранчулууны 2025 оны 49 дугаартай албан бичгээр ирүүлсэн Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг орон сууцжуулах талаар асуусан асуултын дагуу холбогдох мэдээллийг гаргаж 2025 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 01/4417 дугаартай албан бичгээр хүргүүлэв.</p>		
3.	<p>Арга хэмжээ 3.3: Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмийг чанд сахих, ашиг сонирхлын зөрчилгүй ажиллах.</p>	<p>Ёс зүй, ашиг сонирхлын зөрчлийн тоо</p>	-	-	<p>Тайлант хугацаанд хариуцсан чиг үүргээ биелүүлэх хүрээнд төрийн албан хаагчийн ёс зүйн дүрэм болон бусад холбогдох хуульд заасны дагуу ашиг сонирхлын зөрчилгүй хуулийн хүрээнд ажиллав. Энэ хүрээнд 2024 оны хөрөнгө, орлогын мэдүүлгээ холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд meduuleg.iaac.mn-сайтад хугацаанд нь байршуулав. Урьдчилсан мэдүүлгийг meduuleg.iaac.mn-сайтад хугацаанд нь хүргүүлсэн.</p>	01-12	100%
4.	<p>Арга хэмжээ 3.4: Газрын хариуцах чиг үүргийн хүрээнд холбогдох тушаал, шийдвэр, бодлогын баримт бичигт туссан асуудлын биелэлт, төлөвлөлтийг тухай бүр хугацаанд</p>	<p>Дэд арга хэмжээ 3.4.1 Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний биелэлт</p> <p>Дэд арга хэмжээ 3.4.2 Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн</p>	Гүйцэтгэл	-	<p>100%</p> <p>Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг тухай бүр гаргаж ажиллав.</p> <p>Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хөрөнгө оруулалтын хэрэгжилтийг тухай бүр гаргаж ажиллав.</p>	01-12	100%

0	1	2	3	4	5	6	7
	нь боловсруулж, тайлагнаж ажиллах						
	хөрөнгө оруулалтын хэрэгжилт						
5.	Арга хэмжээ 3.5: Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийг хэрэгжүүлэх.	Өргөдөл, гомдол албан бичгийг шийдвэрлэлтийн хувь	-	100%	Тайлант хугацаанд Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийг хэрэгжүүлэн ажилласан. Тус хугацаанд нийт 58 албан бичиг ирсэн ба үүний 42 нь хариутай бичиг ба 7 өргөдөл гомдол ирснийг тухай бүр шуурхай хуулийн хугацаанд нь холбогдох хариу, чиглэлийг өгөн ажиллалаа.	01-12	100%

НЭМЭЛТ ҮҮРЭГ ДААЛГАВАР (АРГА ХЭМЖЭЭ)-ЫН БИЕЛЭЛТ

Д/д	Үүрэг даалгавар	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин, биелэлт	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
0	1	2	3	4	5	6	7
1.	Үүрэг даалгавар:1 Үндэсний орон сууцжуулалтын тухай анхдагч хуулийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх ЗГҮАХХАХТ: 2.4.1.1 №463	Боловсруулалтын хувиар	-	30	Үндэсний орон сууцжуулалтын анхдагч хуулийн төслийн үзэл баримтлалыг Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу Сангийн яам, Хууль зүй дотоод хэргийн яам, Гэр бүл хөдөлмөр нийгмийн хамгааллын яаманд батлуулахаар хүргүүлснээс Гэр бүл хөдөлмөр нийгмийн	01-12	100%

0	1	2	3	4	5	5	7
					<p>хамгааллын яамнаас батлан ирүүлэх хүлээгдэж байна.</p> <p>Хуулийн төслийг байгууллагын https://mcud.gov.mn/forum/42 цахим хаягт байршуулан иргэд олон нийтээс санал авч байна.</p> <p>Ерөнхий сайдын 45 дугаар захирамж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2025 оны 112-р тушаалаар тус тус байгуулагдсан ажлын хэсгийн чиг үүргийн хүрээнд боловсруулагдаж буй “Орон сууцжуулалтын тухай” болон “Орон сууцны санхүүжилтын тухай” хуулийн төсөл боловсруулахад холбогдох саналаа өгч, холбогдох албан хаагчид танилцуулах танилцуулгыг бэлтгэсэн.</p>		
2.	<p>Үүрэг даалгавар:2</p> <p>“Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө”-ний төсөл боловсруулах Ажлын хэсгийн нарийн бичгийн ажиллах</p>	<p>Ажлын хэсгээс боловсруулсан төлөвлөгөөний төсөл, Төлөвлөгөөнд тусгахаар хүргүүлсэн санал,</p>	<p>“Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө” УИХ-ын 35 дугаар тогтоолоор батлагсан. Тус төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээ 25</p>	<p>“Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө”-нд тусгуулах салбарын саналыг Ажлын хэсэг ажиллаж, нэгтгэн Эдийн засаг, хөгжлийн яаманд хүргүүлсэн байна.</p>	<p>ХББОСЯ-ны ТНБД-ын 2024 оны А/52 дугаартай тушаалаар байгуулагдсан. “МУ-ын хөгжлийн 2026 оны төлөвлөгөөний төсөл”-д тусгуулах салбарт хэрэгжүүлэх арга хэмжээний санал боловсруулан 2025 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 01/159 дугаартай албан бичгээр ЭЗХЯ-нд хүргүүлсэн.</p>	01-03	100%
3.	<p>Үүрэг даалгавар:3</p> <p>Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн хуралдааны 3 дугаар тэмдэглэлээр “Бүсчилсэн зөвлөлүүдийг байгуулж, 2025 оны II улиралд багтаан бүсийн зөвлөлийн өргөтгөсөн хуралдаан” зохион байгуулах үүрэг даалгаврын хүрээнд “Хот төлөвлөлт - Орон</p>	<p>Томилолтын тайлан</p>	-	1	<p>Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн хуралдааны 3 дугаар тэмдэглэлээр “Бүсчилсэн зөвлөлүүдийг байгуулж, 2025 оны II улиралд багтаан бүсийн зөвлөлийн өргөтгөсөн хуралдаан” зохион байгуулах үүрэг даалгаврын хүрээнд “Хот төлөвлөлт - Орон сууцжуулах бодлого” салбар хуралдаан зохион байгуулах үүрэг бүхий Ажлын хэсгийн нарийн</p>	01-06	100%

0	1	2	3	4	5	5	7
	сууцжуулах бодлого” салбар хуралдаан зохион байгуулах үүрэг бүхий Ажлын хэсгийн нарийн бичгийн ажиллах				бичгийн ажиллаж, Хангай, Хойд, Говийн бүсийн хуралдааны бэлтгэл ажлыг ханган ажиллав. Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар 2025 оны 05 дугаар сарын 11-13-ны өдрүүдэдт Дорноговь аймгийн Сайншанд хотод Говийн бүсийн өргөтгөсөн хуралдаанд оролцож, томилолтын тайланг боловсруулан СХОГ-т хүргүүлэв.		
4.	Үүрэг даалгавар:4 Засгийн газрын “Агаарын бохирдлыг бууруулах талаар авах зарим арга хэмжээний тухай” 2025 оны 133 дугаар тогтоолыг хэрэгжилтийг хангах зорилгоор Дулаан байшин-Нээлттэй өдөрлөг арга хэмжээний зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсэгт ажиллах	Арга хэмжээний тайлан	-	1	Дулаан байшин-Нээлттэй өдөрлөг арга хэмжээний зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсэгт ажиллаж, арга хэмжээг зохион байгуулах төлөвлөгөө, санхүүгийн тооцоо, удирдамж гэх мэт баримт бичгийг боловсруулан ажиллав. Тус арга хэмжээний тайланг боловсруулж хамтран ажилласан байгууллагуудад 2025 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн 03/1982 дугаартай албан бичгээр хүргүүлэв.	04-05	100%
5.	Үүрэг даалгавар:5 “Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-д төсөл, арга хэмжээг тусгуулах ажлыг зохион байгуулах.	Саналын тоо	“Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийг УИХ-ын 2020 оны 23 дугаар тогтоолоор баталсан.	“Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-д тусгах хөтөлбөр, төсөл, арга хэмжээний саналыг Эдийн засаг, хөгжлийн яаманд хүргүүлсэн байна.	Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэхэд чиглэсэн, хөгжлийн зорилтот хөтөлбөрт нийцүүлж Монгол Улсын дунд хугацааны, төлөвлөлтийн баримт бичиг болох “Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн төслийг үр дүнд суурилсан нэгдсэн төлөвлөлтийн арга зүйд тулгуурлан боловсруулах үүрэг бүхий Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 08 дугаар сарын 07-ны өдрийн А/109 дугаар тушаалаар байгуулсан ажлын хэсэгт ажиллаж орон сууцжуулалтын салбарын нөхцөл байдлын дүн шинжилгээ хийж, хэрэгцээ,	07-12	100%

0	1	2	3	4	5	5	7
					асуудал, асуудлыг шийдвэрлэх арга зам /стратегий/-ыг тодорхойлж урт хугацааны хөгжлийн бодлогын зорилго, зорилтын тухайн таван жилд хүрэх үр дүн, тоон болон чанарын шалгуур үзүүлэлтийг боловсруулсан.		
6.	<p>Үүрэг даалгавар:6</p> <p>Эд хөрөнгийн комисст ажиллах тооллогын</p>	ТНБД-ын А/105	-	Тооллого, хийж тайлагнах	<p>Монгол Улсын Яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.8, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.2 ,72 дугаар зүйлийн 72.1 нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 ,12.2.1 дэх хэсгийг үндэслэн Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн А/105 дугаар тушаалаар эд хөрөнгийн тооллогын комисс байгуулан 2025 оны эхний хагас жилээр эд хөрөнгийн тооллогыг 2025 оны 06 сар болон 08 сард тус тус 2 удаа явуулсан.</p> <p>Тус яамны эд хөрөнгийг тооллогын комисс биечлэн тоолох үйл ажиллагааг зөрчил, доголдолгүй хэвийн гүйцэтгэж дууслаа. Эд хөрөнгийг тоолж бүртгэж тооллогын баримт, хариуцагчийн картыг санхүүгийн тайлантай тулган тооцоог гарган нягтлан бодогчоор хянуулж, эд хөрөнгийн тооллогын илтгэх хуудсыг комиссын даргаар баталгаажуулж, Өмч хамгаалах салбар зөвлөлд танилцуулсан. Мөн тооллоготой холбоотой хурлын тэмдэглэл, илтгэх хуудас болох бусад бүх баримт материалыг СХОГ-т хүлээлгэн өгсөн.</p>	06-09	100%

0	1	2	3	4	5	5	7
7.	<p>Үүрэг даалгавар:7</p> <p>Залуучуудын хөгжлийн төлөөх түншлэл "Амьдрах орчин ба орон сууц" сэдэвт уулзалт хэлэлтцүүлэг зохион байгуулах</p>	Хэлэлцүүлэг	-	-	<p>Залуучуудын хөгжлийн төлөөх түншлэлтэй хамтран "Амьдрах орчин ба орон сууц" сэдэвт уулзалт, хэлэлцүүлэг 2025 оны 10 дугаар сарын 10-ны өдөр зохион байгуулж, салбарын төрийн болон төрийн бус байгууллага, төслийн нэгж, хувийн хэвшлийн аан байгууллагуудын төлөөлөл оролцлоо.</p> <p>Хот байгуулалт, барилга орон сууцжуулалтын салбарт залуучуудын чиглэлээр авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, нөхцөл байдлын талаарх судалгаа мэдээллийг танилцуулж залуучуудын оролцоонд суурилсан санал хүсэлт, тулгамдаж буй асуудлуудыг хэлэлцүүлэн, нарийвчлан эрэмбэлж зөвлөмж, бодлогын шийдвэрийг боловсруулах зорилготой зохион байгуулагдсан.</p> <p>Салбарын залуу албан хаагчид өөрсдийн өмнө тулгамдаж буй асуудлуудаа дэвшүүлж, хэрхэн шийдвэрлэх арга замын талаар ярилцсанаас гадна өсвөр үе, залуучуудыг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сэдвийн хүрээнд хэлэлцүүлгийг өрнүүлж, гарсан үр нэгтгэн ТЗУГ-т хүргүүлэв.</p>	09-10	100%
8.	<p>Үүрэг даалгавар:8</p> <p>"Төрийн албан хаагчид, ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн багш, эмч нарт зориулсан орон сууцны хөнгөлөлттэй зээлийн хөтөлбөр болон шаардагдах санхүүжилтийн эх үүсвэрийн талаар судлан, санал боловсруулах</p>	Төлөвлөгөөний төслийн тоо	-	1	<p>Ерөнхий сайдын 124 дүгээр захирамжаар байгуулагдсан "Төрийн албан хаагчид, ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн багш, эмч нарт зориулсан орон сууцны хөнгөлөлттэй зээлийн хөтөлбөр болон шаардагдах санхүүжилтийн эх үүсвэрийн талаар судлан, санал боловсруулах" чиг үүрэг бүхий Ажлын хэсгийн гүйцэтгэх ажлын</p>	11-12	100%


0	1	2	3	4	5	5	7
					төлөвлөгөөний төсөл боловсруулж, 2025.12.03-ны өдрийн ажлын хэсгийн хуралд танилцуулав.		

Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээ

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэл -тийн хувь
1.	Арга хэмжээ 1. Байгууллагаас зохион байгуулагдах сургалт, арга хэмжээнд тогтмол оролцоно.	Суралцах сургалтын тоо	-	1	<ul style="list-style-type: none"> - E-Mongolia Academy-аас зохион байгуулсан Төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн систем /ERP/-ийн хэрэглээний талаар сургалтад 2025 оны 01 дүгээр сарын 31-ний өдөр хамрагдав. - Батлан хамгаалах яамнаас зохион байгуулсан батлан хамгаалах үйл ажиллагааны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийн талаар сургалтад 2025 оны 05 дугаар сарын 22-ны өдөр хамрагдав. - Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн санал боловсруулах талаар сургалтад 2025 оны 08 дугаар сарын 04-ны өдөр хамрагдав. 	01-12	100%
2	Арга хэмжээ 2. Хөрөнгийн үнэлгээний сургалтад хамрагдана	Суралцах сургалтын тоо	-	1	Монголын мэргэшсэн үнэлгээчдийн институтаас 2025 оны 03 дугаар сард зохион байгуулсан Хөрөнгийн үнэлгээний боловсрол олгох /134 цаг/-ийн сургалтад хамрагдаж мэргэшсэн үнэлгээчний шалгалтад орох эрхийн гэрчилгээ авсан.	01-06	100%

ТАЙЛАН БОЛОВСРУУЛСАН:

**Орон сууцны санхүүжилт, зээлийн судалгаа,
төлөвлөлт хариуцсан ахлах мэргэжилтэн**
(Албан тушаал)

С.Бүжмаа /  /
(Нэр, гарын үсэг)

.....
(Огноо)

ОРОН СУУЦНЫ САНХҮҮЖИЛТ, ЗЭЭЛИЙН СУДАЛГАА, ТӨЛӨВЛӨЛТ ХАРИУЦСАН
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН СОДНОМДАРЖАА ОВОГТОЙ БҮЖМААГИЙН 2025 ОНЫ
ЖИЛИЙН ЭЦСИЙН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН, МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ
ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

Байгууллагын нэр: Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам

Нэгжийн нэр: Хот байгуулалт, орон сууцжуулалтын бодлого, зохицуулалтын газар

1. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний гүйцэтгэлд өгсөн оноо	Төлөвлөсөн хугацаанд гүйцэтгэсэн байдал	Нийлбэр оноо	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо
	1	2	3	4	5
	Оноо	60 хүртэл	10 хүртэл	70 хүртэл	
Зорилт 1. “Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд”					
1.	Арга хэмжээ 1.2.2.1 Арга хэмжээ: “Миний анхны байр” хөтөлбөрийг хэрэгжүүлж, залуу гэр бүл анх удаа байр худалдан авахад нь дэмжлэг үзүүлэх ЗГҮАХХҮТ 1.4.1.5, N466	60	10	70	
2.	Арга хэмжээ 1.2.2.2 Ипотекийн хөнгөлөлттэй зээлийн бүтээгдэхүүнийг төрөлжүүлж, хүүг ялгаатай тогтоох замаар зах зээлийн зарчимд нийцүүлэх ЗГҮАХХҮТ 2.4.1.2, N467	60	10	70	
3.	Арга хэмжээ 1.2.2.3 “Миний сонголт орон нутаг” хөтөлбөрийн хүрээнд Улаанбаатар хотоос орон нутагт шилжин суурьшсан болон аймаг, сум, Улаанбаатар хотын алслагдсан дүүрэгт анх удаа орон сууц худалдан авах иргэдэд арилжааны банкнаас олгох ипотекийн зээлийг 3%-ийн хүүтэй хөнгөлөлттэй нөхцлөөр олгох бодлогыг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ. ЗГҮАХХҮТ 2.4.1.8 №467 ЗГҮАХХҮТ: 1.2.2.2, 1.4.1.2, 2.4.1.2 №468, 2.4.1.8 №476	60	10	70	
4.	Арга хэмжээ: Залуу гэр бүл орон сууц худалдан авахад зориулж урьдчилгаа төлбөрт нь батлан даалт гаргадаг тогтолцоог бий болгох ЗГҮАХХҮТ: 2.1.1.35	60	10	70	
5.	Арга хэмжээ 1.2.2.5 Ипотекийн зээлийн санхүүжилтийн эх үүсвэрийг нийслэлийн гэр хорооллын дахин төлөвлөлтийн байршлуудад тэргүүн ээлжинд олгуулах арга хэмжээг зохион байгуулна. ЗГҮАХ: 1.1.3.3 ЗГҮАХХҮТ: 39	60	10	70	
6.	Арга хэмжээ 1.2.2.6 “Хашаандаа сайхан амьдаръя” хөтөлбөрийг хэрэгжүүлж, эрчим хүчний хэмнэлттэй, байгаль орчинд ээлтэй, амины орон сууц шинээр барих, засварлахад хөнгөлөлттэй зээл болон бусад дэмжлэг үзүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлнэ.	60	10	70	

	ЗГҮАХХҮТ: 1.1.3.7, 2.4.1.5, 2.4.2.2, 3.4.2.9,				
7.	Арга хэмжээ 1.2.2.7 “Миний амины орон сууц” хөтөлбөрийн хүрээнд гэр хорооллын иргэдэд эрчим хүчний хэмнэлттэй амины орон сууц барьсан тохиолдолд 30 сая төгрөгийн санхүүжилтийн дэмжлэг үзүүлнэ. ЗГҮАХ: 2.4.1.7, ЗГҮАХХАХТ: 2.4.1.7 № 475, 3.4.2.9	60	10	70	
Зорилт 3. “Төрийн жинхэнэ албан хаагчийн нийтлэг үүргийг хэрэгжүүлж ажиллах”					
8.	Арга хэмжээ 3.1 Дээд шатны байгууллага, бусад яамд, холбогдох газруудаас санаачлан боловсруулсан хууль тогтоомж, бодлого, төлөвлөлтийн баримт бичгүүдэд санал өгч, салбар хоорондын зохицуулалтыг хангаж ажиллах	60	10	70	
9.	Арга хэмжээ 3.2 Хариуцсан асуудлаар дээд шатны байгууллага, удирдлага, холбогдох байгууллага, иргэдийг бодит мэдээ, мэдээллээр хангаж ажиллах	60	10	70	
10.	Арга хэмжээ 3.3 Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмийг чанд сахих, ашиг сонирхлын зөрчилгүй ажиллах	60	10	70	
11.	Арга хэмжээ 3.4 Газрын хариуцах чиг үүргийн хүрээнд холбогдох тушаал, шийдвэр, бодлогын баримт бичигт туссан асуудлын биелэлт, төлөвлөлтийг тухай бүр хугацаанд нь боловсруулж, тайлагнаж ажиллах	60	10	70	
12.	Арга хэмжээ 3.5: Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийг хэрэгжүүлэх.	60	10	70	
Нэмэлт үүрэг даалгаврын биелэлт					
13.	Үүрэг даалгавар 1. Үндэсний орон сууцжуулалтын тухай анхдагч хуулийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх ЗГҮАХХАХТ: 2.4.1.1 №463	60	10	70	
14.	Үүрэг даалгавар 2. “Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө”-ний төсөл боловсруулах Ажлын хэсгийн нарийн бичгийн ажиллах	60	10	70	
15.	Үүрэг даалгавар 3. Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн хуралдааны 3 дугаар тэмдэглэлээр “Бүсчилсэн зөвлөлүүдийг байгуулж, 2025 оны II улиралд багтаан бүсийн зөвлөлийн өргөтгөсөн хуралдаан” зохион байгуулах үүрэг даалгаврын хүрээнд “Хот төлөвлөлт - Орон сууцжуулах бодлого” салбар хуралдаан зохион байгуулах үүрэг бүхий Ажлын хэсгийн нарийн бичгийн ажиллах	60	10	70	
16.	Үүрэг даалгавар 4. Засгийн газрын “Агаарын бохирдлыг бууруулах талаар авах зарим арга хэмжээний тухай” 2025 оны 133 дугаар тогтоолыг хэрэгжилтийг хангах зорилгоор Дулаан байшин-Нээлттэй өдөрлөг	60	10	70	

	арга хэмжээний зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсэгт ажиллах				
17.	Үүрэг даалгавар 5. “Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-д хөтөлбөр, төсөл, арга хэмжээг тусгуулах ажлыг зохион байгуулах.	60	10	70	
18.	Үүрэг даалгавар 6. Эд хөрөнгийн тооллогын комисст ажиллах	60	10	70	
19.	Үүрэг даалгавар:7 Залуучуудын хөгжлийн төлөөх түншлэл “Амьдрах орчин ба орон сууц” сэдэвт уулзалт хэлэлтцүүлэг зохион байгуулах	60	10	70	
20.	Үүрэг даалгавар 8. “Төрийн албан хаагчид, ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн багш, эмч нарт зориулсан орон сууцны хөнгөлөлттэй зээлийн хөтөлбөр болон шаардагдах санхүүжилтийн эх үүсвэрийн талаар судлан, санал боловсруулах	60	10	70	
Дундаж оноо:					

2. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний биелэлтийн хувь	Нийт (15 хүртэл оноогоор)	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо
	1	2	3	4
1.	Арга хэмжээ 1. Байгууллагаас зохион байгуулагдах сургалт, арга хэмжээнд тогтмол оролцоно.		13	
2.	Арга хэмжээ 2. Хөрөнгийн үнэлгээний сургалтад хамрагдана		13	
Дундаж оноо			13	

3. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Нэгжийн даргын үнэлгээ)

Д/д	Үзүүлэлт	Нэгжийн даргын үнэлгээ (0-7 оноо)	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо
	1	2	3
1.	Хандлага, ёс зүй	5	
2.	Дүн шинжилгээ хийх	5	
3.	Асуудал шийдвэрлэх	5	
4.	Хариуцлагатай байдал	5	
5.	Ажлын цаг ашиглалт	5	
Ур чадварын үзүүлэлт (ажлын онцлогоос хамаарсан)			
6.	Мэргэжлийн ур чадвар 1.		
7.	Мэргэжлийн ур чадвар 2.		
8.	Мэргэжлийн ур чадвар 3.		
Дундаж оноо		5	

4. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Хамт олны үнэлгээ)

Д/д	Үзүүлэлт	Хамт олны үнэлгээ (0-8 оноо)
	1	2
1.	Хандлага, ёс зүй	8
2.	Багаар ажиллах	8
3.	Харилцаа	8
Дундаж оноо		8

5. Гүйцэтгэлийн үнэлгээ

Д/д	Үнэлгээний үзүүлэлт	Үзүүлэлт тус бүрийн оноо
1.	Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт (Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт орно.)	(70 хүртэлх оноо) 40
2.	Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт	(15 хүртэлх оноо) 13
3.	Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Нэгжийн даргын үнэлгээ)	(7 хүртэлх оноо) 5
4.	Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Хамт олны үнэлгээ)	(8 хүртэлх оноо) 8
5.	Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт (Аргачлалын 6 дугаар хэсэгт заасан холбогдох заалтыг бичих)	(..... оноо)
Нийт оноо = (Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо + Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний оноо + Хандлага, ёс зүй, ур чадварын оноо (Нэгжийн даргын болон хамт олны үнэлгээ)) - Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу хассан оноо + Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу нэмсэн оноо		96

Үнэлгээ өгсөн:

Хот байгуулалт, орон сууцжуулалтын бодлого, зохицуулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

Нэгжийн дарга


/О.Одбаяр/
2025.12.....

Үнэлгээтэй танилцаж, зөвшөөрсөн:

Орон сууцны санхүүжилт, зээлийн судалгаа, төлөвлөлт хариуцсан ахлах мэргэжилтэн

Төрийн жинхэнэ албан хаагч:


/С.Бүжмаа/
2025.12.....

Үнэлгээг хянасан:

Үнэлгээний багийг төлөөлж ахлагч:

..... /



/ /
2025.12.....

Үнэлгээний багийн нарийн бичгийн дарга:
Хүний нөөцийн бодлого, зохицуулалт
хариуцсан ахлах шинжээч

.....*Алтан*..... /

2025.12.....

Үнэлгээг баталгаажуулсан:

Төсвийн шууд захирагч

Төрийн нарийн бичгийн даргын албан
үүргийг түр орлон гүйцэтгэгч

..... /М.Баяраа/

2025.12.....